

Монгол Улс дахь жижиг, дунд бизнесийн уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх нь

Уур амьсгалын өөрчлөлтөд авах хариу арга хэмжээний
төлөвлөгөө боловсруулах хэрэглэгдэхүүн

© Энд агуулагдсан мэдээллийг задруулах эсвэл ашиглах нь оюуны өмчийн эрхийг зөрчихгүй болно.

Боловсруулсан



Дэмжигч байгууллагууд



IRIM Судалгааны хүрээлэнгийн 11 судлаач Австрали Улсын Засгийн газрын “Australia Awards Fellowship” хөтөлбөрийн хүрээнд “Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, жендэрийн тэгш байдлыг хангасан жижиг дунд бизнес” сэдвээр Австрали Улсын Гриффит их сургуульд 2023 оны 9-10 сард таван долоо хоног мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан. Энэхүү хэрэглэгдэхүүнийг Science into Action байгууллагаас гаргасан “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хэрэглэгдэхүүн”, Квинсландын Засгийн газраас гаргасан “Жижиг бизнесүүдэд зориулсан уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн менежментийн хэрэглэгдэхүүн” болон богино сургалтаар олж авсан мэдлэгт үндэслэн Монгол Улсын жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулан боловсруулсан болно.

Зохиогчид

Б.Батхүү, IRIM судалгааны хүрээлэн
Б.Болор, IRIM судалгааны хүрээлэн
У.Дагийсүрэн, IRIM судалгааны хүрээлэн
П.Цэдэн-Иш, IRIM судалгааны хүрээлэн
Н.Янжинпагма, IRIM судалгааны хүрээлэн
Дэд проф. Роб Хэйлс, Гриффит Их Сургууль

Зөвлөх баг

Профессор Тапан Саркер, Өмнөд Квинсландын их сургууль (UniSQ)
Доктор Дара Шах, Гриффит Их Сургууль
Л.Цэлмэгсайхан, IRIM судалгааны хүрээлэн



Энэхүү QR кодыг уншуулж, хэрэглэгдэхүүнд орсон загвар хүснэгтүүдийг татан авах боломжтой.

Агуулга

Хэрэглэгдэхүүний тухай.....	1
Хэрэглэгдэхүүнийг хэрхэн ашиглах вэ?.....	1
Жижиг, дунд бизнесүүд уур амьсгалын өөрчлөлтөд хариу арга хэмжээ авах төлөвлөгөөг яагаад боловсруулах шаардлагатай вэ?.....	2
I. Уур амьсгалын өөрчлөлтийн хариу арга хэмжээний талаарх урьдач үнэлгээ.....	5
II. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг үнэлэх нь.....	6
III. Уур амьсгалын өөрчлөлтөд хариу арга хэмжээ авах төлөвлөгөөгөө гаргах нь.....	13
IV. Хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжүүлэлт.....	17
V. Хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх болон хянах процесс.....	18
Хавсралт: Хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулахдаа ашиглах боломжтой чухал асуултууд.....	19

Хэрэглэгдэхүүний тухай

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй дэлхий нийтийн сорилтуудад бизнес эрхлэгчид, ялангуяа жижиг, дунд бизнес эрхлэгчид хамгийн ихээр өртөж байна. Монгол улс байгаль, цаг уур, газар зүйн байршлын онцлогоос хамааран уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их эмзэг улс орнуудын нэгт орж буй тул бизнес эрхлэгчид тэдгээр эрсдэлийг ойлгож, хариу арга хэмжээ авах нь уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хөгжилд нэн чухал болж ирээд байна. Ингэж байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжлийг дэмжсэн, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байснаар жижиг, дунд бизнес эрхлэгчид бизнесээ улам хөгжүүлэх, хүчирхэгжүүлж чадна.

Уур амьсгалын өөрчлөлт нь байгаль, цаг уурын үндсэн хэв шинж өөрчлөгдөх, байгалийн гамшигт үзэгдлүүд нэмэгдэх зэргээр илэрч бизнесүүдийн үйл ажиллагаанд шууд нөлөө үзүүлж байна. Нөгөө талаас бизнесүүд уур амьсгалын өөрчлөлтийг нөхцөлдүүлэгч хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад хувь нэмрээ оруулахын тулд асуудлын талаар мэдлэгтэй байх, хариу арга хэмжээний төлөвлөгөөтэй байх нь зайлшгүй шаардлага болоод байна.


Энэхүү хэрэглэгдэхүүн нь Монгол улс дахь жижиг, дунд бизнесүүдийн уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, өөрсдийн бизнес дэх эрсдэлийг үнэлэх, цаашлаад бодитоор хэрэгжүүлж болохуйц уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хариу арга хэмжээг тодорхойлох боломжийг бүрдүүлэхэд чиглэнэ.

Хэрэглэгдэхүүнийг ашигласнаар хэн үр шим хүртэх вэ?

Хэрэглэгдэхүүнийг Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд бизнесүүдэд зориулан боловсруулав. Мөн уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сорилтуудтай нүүр тулж буй бүхий л салбарын бизнесүүд ашиглах боломжтой. Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй бизнесийг бий болгохыг зорьж буй жижиг, дунд бизнесүүдийн эзэд, удирдах түвшний ажилчид, шийдвэр гаргагчдад илүүтэй дэмжлэг болно. Хэрэглэгдэхүүн нь жижиг, дунд бизнесүүдийг уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сорилт, бэрхшээлийг даван туулах хариу арга хэмжээний иж бүрэн төлөвлөгөөтэй болгоход чиглэнэ.

Хэрэглэгдэхүүнийг хэрхэн ашиглах вэ?

Энэхүү хэрэглэгдэхүүнийг ажиллаж дуусгахад дунджаар 45-90 минут зарцуулагдана. Гэхдээ хэрэглэгдэхүүнийг хоёроос гурван өдрийн хугацаанд хамтран ажиллагсадтайгаа идэвхтэй хэлэлцүүлэг өрнүүлэх замаар ажиллаж дуусгах аргачлалыг санал болгож байна. Ингэснээр бизнесийн бүхий л хэсэгт учирч болох уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлийг бууруулахад үр дүнтэйгээс гадна, байгууллагын хамт олны нэгдсэн ойлголт, манлайллыг бий болгох давуу талтай дасгал ажил болох юм. Хангалттай хугацаа зарцуулах нь уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй бизнесийг бий болгох, сорилт бэрхшээлийг орхигдуулахгүй тооцоход чухал ач холбогдолтой гэдгийг санаарай.



Жижиг, дунд бизнесүүд уур амьсгалын өөрчлөлтөд хариу арга хэмжээ авах төлөвлөгөөг яагаад боловсруулах шаардлагатай вэ?

Жижиг, дунд бизнес түүн дотроо эмэгтэй эзэнтэй эсвэл удирдлагатай жижиг, дунд бизнесүүд үд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн эрсдэлийг бууруулах стратеги, бодлогыг үйл ажиллагааны түвшинд авч үзсэнээр тухайн **бизнесийн инновац, өсөлт нэмэгддэг**. Ялангуяа, энэ нь эмэгтэй бизнес эрхлэгчдийн хувьд ихээхэн ач холбогдолтой. Учир нь эмэгтэй эзэнтэй (удирдлагатай) бизнесүүд өөрсдийн онцлогт тохирсон уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлснээр түгээмэл тулгардаг тэгш бус байдлын үр дагаврыг бууруулж, жендерийн тэгш байдал болоод тухайн орон нутгийн эдийн засагт эргээр нөлөөлдөг.

Түүнчлэн судлаачдын үзэж буйгаар, бизнесийн шийдвэр гаргалтад гэр бүлийн гишүүд хамтран оролцсоноор өрхийн санхүүгийн шийдвэр гаргалтууд сайжирдаг. Эмэгтэйчүүдээс гадна, нийгмийн бусад эмзэг бүлгийн төлөөллийг бизнесийн төлөвлөлтийн үйл явцад татан оролцуулах нь эргээд эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг бий болгож, авсан арга хэмжээнээс гарах үр дүнг тэгш хүртээмжтэй, төрөлжсөн, тэсвэртэй, эдийн засгийн өсөлт рүү чиглүүлэхэд хувь нэмэр оруулдаг.

Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй бизнес төлөвлөлтийн хэрэгцээ, шаардлага

Монгол Улсын хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө нэмэгдэж, цөлжилт, усны хомсдол, хур тунадасны хэмжээ өөрчлөгдөж, цаг агаарын эрс тэс үзэгдлүүд ихэссээр байна. Тухайлбал, сүүлийн 80 жилийн хугацаанд Монгол орны жилийн дундаж температур 2.25°C-аар ихсэж, сүүлийн 10 жилийн хугацаанд байгалийн гамшигт, аюулт үзэгдлийн тоо өмнөх 10 жилтэй харьцуулахад хоёр дахин нэмэгджээ¹. Монгол Улсын хэмжээнд бизнес эрхлэгчид, ялангуяа жижиг, дунд бизнесүүд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сорилтууд болон дотоодын эдийн засгийн тогтворгүй байдлаас шалтгаалсан тодорхойгүй, ойлгомжгүй бизнесийн орчинд үйл ажиллагаа явуулж байна. Бизнесүүд уур амьсгалын өөрчлөлт, эдийн засгийн сорилтуудыг даван туулахын тулд уур амьсгалд тэсвэртэйгээр бизнесээ төлөвлөх нь зайлшгүй болоод байна. Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байна гэдэг нь дан ганц болзошгүй аюулаас хамгаалах тухай асуудал бус, харин бизнесийнхээ урт хугацааны тогтвортой байдлыг сайжруулах стратегийн алхам авах тухай юм.

Өнөө үед зах зээл дэх хэрэглэгч, үйлчлүүлэгч, хөрөнгө оруулагч, бүхий л талууд байгаль орчинд ээлтэй бизнесийн үйл ажиллагааг дэмждэг, чухалчилдаг болсон тул бизнесүүд хариу арга хэмжээний төлөвлөгөөтэй байх нь (i) зах зээлд нэвтрэх шинэ гарцыг нээх, (ii) байгаль орчинд санаа тавьдаг хэрэглэгчдийг татах, (iii) шинэ тутам эх үүсвэрээс хөнгөлөлттэй санхүүжилт татахад тусалж байна.

¹Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Уур амьсгал эрсдэлийг орны гурв ёрх- Монгол, 2021



Хариу арга хэмжээний төлөвлөгөө нь дан ганц уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сорилт, бэрхшээлүүдийг даван туулахад бус, тогтвортой болон тэсвэртэй байдлыг чухалчилдаг бизнесүүд өсөж, дэвшихэд нэн ач холбогдолтой.

Тухайлбал, 2023 оны зун Улаанбаатар хотод их хэмжээний аадар бороо орж, үер буусан нь нэг талаас хот төлөвлөлтийн асуудал боловч, нөгөө талаас уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшигт үзэгдэлд бэлэн байх шаардлага хаяанд тулж ирээд байгааг иргэд төдийгүй холбогдох бүхий л талуудад харуулсан. Уг үерт дэлгүүр, оффис, агуулах гэх мэт өдөр тутам үйл ажиллагаа эрхэлдэг бизнесүүд усанд автаж, бараа материал, тоног төхөөрөмж, дэд бүтэц нь сүйдсэн. Эдгээр хохирлыг барагдуулж, эвдэрч, сүйдсэн зүйлсийг засварлаж, солиход ЖДБ-үүд өөрсдийн хөрөнгө, нөөцөө шавхсан билээ. Үерийн улмаас **бизнесийн хэвийн үйл ажиллагаа доголдож, зарим жижиг, дунд бизнесүүд үйлдвэрлэлээ зогсоох, түр хаах эсвэл хүчин чадлаа бууруулж ажиллахад хүрсэн.** Дээрх үйл явдал нь бизнесүүд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн сорилт, бэрхшээлүүдтэй өдөр тутамдаа нүүр тулж, нөлөөлөлд өртөж байгаа боловч, эрсдэлд хариу арга хэмжээ авах чадавхаа бэхжүүлж, уур амьсгалд тэсвэртэй хөгжил, төлөвлөлтийг бий болгох мэдлэг, чадавх дутмаг байгааг тодоор харуулсан жишээ юм.

Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хариу арга хэмжээ гэж юу вэ?

Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хариу арга хэмжээ гэдэг нь уур амьсгалын өөрчлөлт нь бизнесийн үйл ажиллагаанд урт болон богино хугацаандаа үзүүлэх нөлөөлөлд дасан зохицох болон бууруулахад чиглэсэн идэвхтэй хариу арга хэмжээ авах явдал юм. Энэ төрлийн хариу арга хэмжээний төлөвлөгөө нь жижиг, дунд бизнесүүдийг уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлээс хамгаалах болон бизнесийн тогтвортой байдлыг дэмжих боломжуудыг ашиглахад тусална.



Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах гэдэг нь ялгарлыг бууруулах буюу хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлэх эсвэл цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл, тээвэрлэлт зэргээс ялгарах ялгарлыг бууруулах замаар хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах явдал юм. Нөлөөллийг бууруулах нь дэлхий дахины уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад хувь нэмэр оруулна.



Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох гэдэг нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд бэлэн байх явдал юм. Дасан зохицох үйл ажиллагаа нь өөрчлөгдөж буй уур амьсгалын сөрөг нөлөөллийг бууруулах эсвэл өөрчлөгдөж буй уур амьсгалтай холбоотой аливаа боломжийг нэмэгдүүлэх давуу талтай. Энэ нь "уур амьсгалд тэсвэртэй" байх, бидний аль хэдийн туулсан болон ирээдүйд туулах өөрчлөлтүүдэд бэлтгэх тухай ойлголт юм.

Уур амьсгалын өөрчлөлтөд хариу арга хэмжээ авснаар жижиг, дунд бизнесүүдийн хүртэх үр өгөөж:

1. Зардлын хэмнэлт болон оновчтой хөрөнгө оруулалт:

Урт болон богино хугацааны уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй боломжит эрсдэлүүдийн бизнест үзүүлж буй болзошгүй нөлөөллийн талаарх ойлголт, мэдлэгтэй байх нь **оновчтой хөрөнгө оруулалтын шийдвэр** гаргалтад тусална. Энэ нь урт хугацаандаа бизнесийн **үйл ажиллагааны зардлыг удирдах**, улмаар бууруулах боломжийг олгодог. Түүнчлэн, энэ нь ирээдүйд **даатгалын шимтгэл, зээлийн зардлыг бууруулахад** хувь нэмэр оруулна.

2. Бизнесийн тасралтгүй байдал:

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй болзошгүй эрсдэлүүдэд хариу арга хэмжээ авах нь бизнесийн **тэсвэртэй болон тасралтгүй байдлыг дэмждэг**. Ингэснээр бизнесийн үйл ажиллагааг тогтвортой, өсөлттэй үргэлжлүүлэхийн зэрэгцээ, үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээг хангах, байгаль, цаг уурын гамшигт үзэгдлээс үүдэлтэй сорилт, бэрхшээлийг даван туулах, бууруулах боломжийг олгодог.

3. Өрсөлдөх чадвар ба бизнесийн боломжууд:

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлийг ойлгож, түүнд дасан зохицох нь шинэ боломжуудыг нээхэд бизнест тусалдаг. Тухайлбал, (i) **бүтээгдэхүүн, үйлчилгээгээ шинэчлэх**, (ii) **зардал хэмнэх** (iii) **уур амьсгалтай холбоотой эрсдэлийг илүү үр дүнтэй удирдах** боломжийг олгодог. Энэ нь тухайн бизнесийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлдэг.

4. Эерэг нэр хүнд ба хөрөнгө оруулагчдын итгэл:

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг удирдах нь бизнесийн **үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлэхийн зэрэгцээ**, бизнесийн нэмүү өртгийн сүлжээний бусад **оролцогч талуудад эергээр нөлөө үзүүлдэг**. Тухайлбал, хэрхэн бизнесээ байгаль орчинд ээлтэй, уур амьсгалд тэсвэртэйгээр эрхэлж буйгаа танилцуулах замаар хэрэглэгч, үйлчлүүлэгчид, ханган нийлүүлэгчид, хувьцаа эзэмшигчдийн дунд нэр хүндээ нэмэгдүүлэх боломжтой. Энэ нь эргээд хөрөнгө оруулагчдад итгэл төрүүлж, бизнесийн зах зээлд эзлэх байр суурийг нь бэхжүүлдэг.



I. Уур амьсгалын өөрчлөлтийн хариу арга хэмжээний талаарх урьдач үнэлгээ

Энэхүү урьдач нөхцөл байдлын үнэлгээний зорилго нь жижиг, дунд бизнес эрхлэгчид уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сорилт, бэрхшээлүүдэд дасан зохицох, бууруулахад чиглэсэн хариу арга хэмжээний бэлэн байдлын түвшнийг тодорхойлоход чиглэнэ. Үнэлгээ нь 8 үзүүлэлтийг 1-3 оноогоор үнэлэх асуумжаас бүрдэнэ.

Та өөрийн одоогийн мэдлэг, бизнесийн туршлага дээрээ тулгуурлан асуулт бүрд өгөгдсөн хариулт (тийм бол 1, зарим талаар бол 2, үгүй бол 3) онооны аль нэгийг сонгоно. Бүх асуултад хариулсны дараагаар, нийт оноогоо тооцож, одоогийн байгаа түвшнээ үнэлсний дараагаар уг хэрэглэгдэхүүнийг цааш үргэлжлүүлэн ажиллах эсэхээ шийднэ үү.

	1	2	3
1. Та уур амьсгалын өөрчлөлтөд өөрийн бизнесээ хэрхэн дасан зохицуулах талаар ойлголттой юу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Зарим талаар	<input type="checkbox"/> Үгүй
2. Та өөрийн бизнесийн үйл ажиллагаа явагдаж буй орон нутгийн байршлын онцлогоос үүдэн гарах уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн талаар мэдэх үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Зарим талаар	<input type="checkbox"/> Үгүй
3. Танай бизнест уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэл тохиолдоход ойролцоогоор ямар хэмжээний зардал учрахыг та мэдэх үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Зарим талаар	<input type="checkbox"/> Үгүй
4. Уур амьсгалын өөрчлөлт болон байгалийн гамшигт нөхцөл байдалд танай бизнесийн үйл ажиллагаа (ажиллах хүч, үл хөдлөх хөрөнгө, нийлүүлэлтийн сүлжээ, үйлчлүүлэгч гэх мэт) хэр эмзэг, өртөмтгий болохыг та мэдэх үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Зарим талаар	<input type="checkbox"/> Үгүй
5. Та уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшигт үзэгдлийн нөлөөлөлд өртөмтгий байдлыг бууруулахын тулд бизнесийн үйл ажиллагаандаа ямар өөрчлөлтүүд хийх талаар мэдэх үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Зарим талаар	<input type="checkbox"/> Үгүй
6. Танд уур амьсгалын өөрчлөлтөд бэлэн байхын тулд бизнесийн үйл ажиллагаагаа хэрхэн өөрчлөх талаар тусгасан тодорхой хариу арга хэмжээний төлөвлөгөө бий юу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Зарим талаар	<input type="checkbox"/> Үгүй
7. Та бизнестээ зориулан уур амьсгалын өөрчлөлтийн хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлсэн үү?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Зарим талаар	<input type="checkbox"/> Үгүй
8. Та бизнесийнхээ уур амьсгалын өөрчлөлтийн хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянадаг уу?	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Зарим талаар	<input type="checkbox"/> Үгүй
Нийт оноо	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>

Зааварчилгаа: Урьдач нөхцөл байдлын үнэлгээний 8 асуултын хариултын нийлбэр оноо нь 15-аас их байгаа тохиолдолд хэрэглэгдэхүүний дараагийн хэсгүүдийг үргэлжлүүлэн ажиллах зайлшгүй шаардлагатай бол, 10-15 оноо авсан тохиолдолд мөн адил хэрэглэгдэхүүнийг үргэлжлүүлэн ажиллахыг санал болгоно. Харин 10-аас бага оноо авсан тохиолдолд заавал цааш үргэлжлүүлэн ажиллахыг санал болгохгүй.

- 10 - аас бага оноо **Хэрэглэгдэхүүнийг ашиглах эсэх сонголтыг танд үлдээж байна.**
Уур амьсгалд хариу арга хэмжээ үзүүлэх одоогийн төлөвлөгөөгөө хянах зорилгоор энэхүү хэрэглэгдэхүүнийг ашиглаж болох юм.
- 10 – 15 оноо **Хэрэглэгдэхүүнийг бөглөхийг санал болгож байна.**
Уур амьсгалын өөрчлөлтөд бизнесийн үйл ажиллагаагаа хэрхэн зохицуулах талаар бодлоо цэгцлэхийн тулд энэхүү хэрэглэгдэхүүнийг ашиглаарай.
- 15 - аас их оноо **Хэрэглэгдэхүүнийг дуустал нь бөглөнө үү.**
Уур амьсгалын өөрчлөлтөд зориулж бизнесээ төлөвлөх, дасан зохицуулахын тулд энэхүү хэрэглэгдэхүүнийг заавал ашиглаарай.

Эх сурвалж: SECCCA, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хэрэгилдэхүүн

II. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг үнэлэх нь

2.1 Уур амьсгалын өөрчлөлтийн өнгөрсөн болон одоогийн нөлөөлөл

Уур амьсгалын өөрчлөлтийн Монголд үзүүлж буй нөлөөлөл

Өнөөгийн байдлаар хүн төрөлхтний өмнө хамгийн их тулгамдаж буй асуудал бол уур амьсгалын өөрчлөлт юм. Уур амьсгалын өөрчлөлт нь хүрээлэн буй орчноос гадна хүн ам, экосистем болон эдийн засагт сөргөөр нөлөөлсөөр байна. Монгол Улсын хувьд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэйгээр газрын гарц буурах, биологийн төрөл зүйлүүд устаж үгүй болох, улирлын хэв шинж өөрчлөгдөх, хэт халуун, хүйтэн өдрүүдийн тоо нэмэгдэх, цөлжилт ихсэх зэрэг олон сөрөг үр дагаварт хүргэж байна. Монголд уур амьсгалын өөрчлөлтийн улмаас гарсан өөрчлөлтүүдийг дор дурдав

1. Агаарын Температур болон Хур тунадасны өөрчлөлт²:



- Сүүлийн 80 жилийн хугацаанд агаарын хэмийн дундаж температур 2.25°C -ээр нэмэгдсэн.
- Хүйтэн өдрийн дундаж тоо 15-аар буурч, халуун өдрийн дундаж тоо 24-өөр мэдэгдэхүйц нэмэгдсэн.
- Зуны улирлын нийт хур тунадасны хэмжээ 7%-аар буурсан бол, эсрэгээрээ өвлийн улирлын хур тунадасны хэмжээ 22%-аар ихэссэн байна.

2. Байгалийн гамшигт үзэгдлүүд:



- Зуны улирлын хур тунадасны хэмжээ багасах, хүйтний эрч сулрах зэргээс үүдэн ган, гачгийн давтамж улам эрчимжсээр байгаа нь хуурайшилт удаан үргэлжлэх шалтгаан болж байна.
- Хэт халуун өдрийн тоо нэмэгдсэнээр бэлчээрийн талбай доройтож, мал аж ахуй, газар тариалан зэрэг хөдөө аж ахуйн салбаруудад сөрөг үр дагавар, нөлөөлөл бий болж байна.
- Өнгөрсөн арван жилийн хугацаанд байгалийн гамшигт үзэгдлийн тоо хоёр дахин нэмэгдсэн нь бэлэн байдлыг өндөржүүлэх суурь нөхцөл, шаардлага болж байна.



3. Экосистемд үзүүлж буй нөлөө:

- Ойн хомсдол, доройтол нэмэгдэж, ойн талбайн эзлэх хэмжээ буурч байна.
- Нийт нутаг дэвсгэрийн 76.8% нь цөлжилт болон газрын доройтолд өртсөн.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд бизнесүүдэд уур амьсгалын өөрчлөлтийн өнгөрсөн дэх үзүүлсэн нөлөөлөл:

Уур амьсгалын өөрчлөлт нь бүхий л төрлийн бизнесийн салбарт шууд болон шууд бус байдлаар сөргөөр нөлөөлж байна.



²Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн, Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлээний шийм, 2021

Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагаварт бизнесүүд дараах байдлаар өртөж байна. Үүнд:

1. Ажиллах хүчин:



- **Хэт халалттай холбоотой эрүүл мэндийн асуудлууд гарах:** Хэт халалтын улмаас ажилчид эрүүл мэндийн асуудлуудтай тулгарч байгаа нь тэдний ажлын бүтээмжид сөргөөр нөлөөлж байна.
- **Ажлын байр руугаа явахад бэрхшээлтэй болох:** Үер, цасан шуурга зэрэг байгалийн гамшигт үзэгдлүүдийн улмаас ажлын байр руугаа явахад бэрхшээл үүсэж, ажил тасралтгүй явагдах нөхцөлийг бууруулж байна.

2. Хэрэглэгчид, ханган нийлүүлэгчид болон бусад холбогдох талууд:



- **Нийлүүлэлтийн сүлжээ тасалдах:** Байгалийн гамшигт үзэгдлүүдийн улмаас бизнесийн нийлүүлэлтийн сүлжээнд тасалдал үүсэж, хэрэглэгчдэд хүрэх бүтээгдэхүүний хүртээмжид нөлөөлөх ба энэ нь бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ, хадгалалт, хангамжид нөлөөлснөөр иргэдийн орлого, амьжиргаанд нөлөөлөх суурь нөхцөл болж байна.
- **Хэрэглэгчдийн эрэлт өөрчлөгдөх:** Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хэрэглэгчдийн хүсэл, сонирхол өөрчлөгдөж, байгальд ээлтэй, тогтвортой хөгжлийг дэмжсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт нэмэгдэж байна.

3. Хөрөнгө, Дэд бүтэц болон Нөөц:



- **Дэд бүтцэд биет гэмтэл учрах:** Хүчтэй салхи шуурга, үер болон ой хээрийн түймрийн улмаас дэд бүтэц, барилга байгууламжууд эвдэрч, өндөр өртгөөр засвар хийхэд хүргэж байна.
- **Засвар үйлчилгээний өртөг, зардал нэмэгдэх:** Байгалийн гамшиг үзэгдлээс үүдэн бий болсон элэгдэл хорогдлын улмаас эд хөрөнгө болон дэд бүтцийн засвар үйлчилгээний зардлууд нэмэгдэж байна.

4. Логистик болон нийлүүлэлтийн сүлжээ:



- **Тээвэрлэлтийн сүлжээ тасалдах:** Хүчтэй салхи шуурга, үер гэх мэт байгалийн гамшигт үзэгдлийн улмаас тээвэрлэлтийн сүлжээ тасалдах, саатал үүсэх, логистикийн зардал нэмэгдэх зэрэг асуудлууд үүсэж байна.
- **Нийлүүлэлтийн сүлжээнд эрсдэл үүсэх:** Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлүүд нь бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээнд тасалдал үүсгэж, хүртээмжтэй байдлыг бууруулж байна.

5. Аюулгүй байдал:



- **Эрсдэлд өртөх магадлал нэмэгдэх:** Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас ажилтнууд болон эд хөрөнгө эрсдэлд өртөх магадлал улам бүр нэмэгдэж байгаагаас шалтгаалан амь нас, эд хөрөнгөө алдах тохиолдол нэмэгдэж байна.
- **Байгалийн гамшигт өртөмтгий байдал нэмэгдэх:** Бизнесүүд байгалийн гамшигт үзэгдэлд өртөх эрсдэл нь нэмэгдсэнээр аюулгүй байдал болон хамгаалалтын арга хэмжээний санхүүжилтийн зардал нэмэгдэх, хариуцсан хүний нөөц нэмэгдэх зэрэг нэмэлт шаардлагууд бий болж байна.

6. Санхүү ба санхүүгийн менежмент:



- **Даатгалын зардал өсөх:** Уур амьсгалын өөрчлөлтөөс улбаалан эрсдэлүүд нэмэгдэж байгаа тул бизнесүүд даатгалын үйлчилгээнд зардал, санхүүжилтийг төлөвлөх шаардлага бий болж байна.
- **Үйл ажиллагааны зардал нэмэгдэх:** Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэл, сорилтыг даван туулахын тулд бизнесүүд эрчим хүч нөөцлөх эсвэл өөр төрлийн тээврийн хэрэгсэл ашиглах гэх мэт нэмэлт нөөц эх үүсвэрүүдийг ашиглаж, үүнийг дагасан үйл ажиллагааны зардал нь нэмэгдэж байна.

Энэхүү хэрэглэгдэхүүний зорилго нь бизнесийн аль хэсэгт аюул, эрсдэл тулгарч, тэдгээр нь бизнесийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлснийг тодорхойлох юм. Бизнесийн ажиллах хүч, ханган нийлүүлэлтийн сүлжээ, хөрөнгө зэрэг үйл ажиллагаанд нөлөөлсөн ган, зуд, үер зэрэг урьд өмнө тохиолдож байсан аливаа эрсдэлийг доорх хүснэгтэд жагсааж, эдгээр эрсдэлүүд нь бизнесийн хэсэг тус бүрд хэрхэн нөлөөлсөн талаар тайлбарлан бичнэ үү.

Бизнесийн үйл ажиллагаа, бүтэц эсвэл үйл явц	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй аюулууд өнгөрсөн хугацаанд танай бизнест нөлөөлсөн үү?	Ямар аюулууд байсан бэ? (нэгээс олон аюул байж болно).	Өнгөрсөн хугацаанд таны бизнесийн энэ хэсэгт аюул (үйл явдал) хэрхэн нөлөөлснийг дэлгэрэнгүй бичнэ үү.
Ажиллах хүчин	Тийм / Үгүй		
Хэрэглэгчид, ханган нийлүүлэгчид болон голлох оролцогч талууд	Тийм / Үгүй		
Хөрөнгө, дэд бүтэц болон нөөц	Тийм / Үгүй		
Логистик болон нийлүүлэлтийн сүлжээ	Тийм / Үгүй		
Аюулгүй байдал	Тийм / Үгүй		
Санхүү ба санхүүгийн менежмент	Тийм / Үгүй		
Бизнесийн үйл явц систем, дата болон мэдээллийн технологи	Тийм / Үгүй		
Бусад (Аюулд өртсөн бизнесийн бусад элементийг энд нэмнэ үү.)	Тийм / Үгүй		

2.2 Уур амьсгалын өөрчлөлтөөс бий болох ирээдүйн нөлөөлөл

Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйд үзүүлэх УРТ ХУГАЦААНЫ нөлөөлөл

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой урт хугацаанд гарах өөрчлөлтүүдийг тооцоолон гаргасан байдаг. Тухайлбал, 2050 он гэхэд дундаж температур 2-3 хэмээр өсөх, зуны улиралд хур тунадас бага орох, өвлийн улиралд хур тунадасны хэмжээ нэмэгдэж, цагаан зуд болох, хүчтэй салхи шуурга, аюулт үзэгдлүүдийн давтамж 23-60% хүртэл өсөх хандлага ажиглагдаж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйд үзүүлэх нөлөөллийг дор дэлгэрэнгүй харуулав.

1. Агаарын температур болон хур тунадасны өөрчлөлт³:



- Улирлын агаарын температур энэ зууны эхэн үед 2.0-2.3°C, төгсгөлд 2.4-6.3°C-ээр тогтвортой нэмэгдэнэ.
- Хүйтэн өдрийн тоо 10-40 хоногоор буурах, халуун өдрийн 7-36 хоног нэмэгдэх бөгөөд дараалсан халуун өдрийн тоо 6-54 хоногоор нэмэгдэнэ.
- Өвлийн хур тунадас энэ зууны эхэн үед 10.1-14%, төгсөлд 15.5-50.2%-аар дунджаар нэмэгдэнэ.
- Зуны хур тунадас зууны эхэн үед 1.1-6.2%, төгсөлд үед 5.1-7.8%-аар нэмэгдэнэ.

2. Цаг агаарын онц ноцтой үзэгдлүүд:



- Гангийн давтамж 5-45%-аар нэмэгдэнэ.
- Зудын давтамж 5-40%-аар нэмэгдэнэ.
- Цөлжилт нэмэгдэнэ.
- Байгалийн аюул гамшигт үзэгдлийн давтагдал 23-60%-аар нэмэгдэнэ.

3. Экосистемд үзүүлэх нөлөөлөл:



- Ойн эзлэх талбай багасаж, ой ургах нөхцөл улам хумигдана.
- Царцааны тархалт ихсэх хандлагатай байна.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд бизнесүүдэд уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйд үзүүлэх УРТ ХУГАЦААНЫ нөлөөлөл:

Жил ирэх тусам уур амьсгалын өөрчлөлт эрчимжихийн хэрээр бизнесүүд илүү хүнд нөхцөлтэй нүүр тулгарч олон өөрчлөлтүүдийг хийх хэрэгтэй болно.



³Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн, Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлээний тойм, 2021

Уур амьсгалын өөрчлөлт урт хугацаандаа бизнесүүдэд дараах байдлаар нөлөөлж болзошгүй байна. Үүнд:

1. Ажиллах хүчин:



- **Хэт халуунаас үүдсэн стресс нэмэгдэх:** Хэт халалтын улмаас ажилчдын стресст өртөх эрсдэл нэмэгдэх
- **Зайнаас ажиллахтай холбоотой сорилтууд:** Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн дэд бүтэц болон харилцаа холбооны системд доголдлууд үүсэж, ажилчдын зайнаас ажиллах чадварт сөргөөр нөлөөлнө.

2. Хэрэглэгчид, ханган нийлүүлэгчид болон бусад холбогдох талууд:



- **Хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлага өөрчлөгдөх:** Хэрэглэгчдийн хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээ, шаардлага, худалдан авалтын шийдвэрүүд нь бизнесүүдийг байгальд ээлтэй, тогтвортой чиглэл рүү үйл ажиллагаагаа шилжүүлэхийг шаардана.
- **Зохицуулалтын өөрчлөлт:** Уур амьсгалын өөрчлөлт, өртөмтгий салбарууд, тэдгээрийн харилцаа холбоо зэргийг зохицуулах шинэ дүрэм журам, зохицуулалтууд бий болох.

3. Хөрөнгө, Дэд бүтэц болон Нөөц:



- **Дэд бүтцийн эмзэг байдал:** Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөө нь дэд бүтцийн эмзэг байдлыг нэмэгдүүлж улмаар эрсдэлд тэсвэртэй төлөвлөлтөд хөрөнгө оруулах хэрэгцээ, шаардлагыг бий болгоно.
- **Нөөцийн хомсдол:** Ирээдүйд гол нөөцүүд хомсдолд орж болзошгүй учраас бизнесүүдийн зардал өсөж, нөөцийн хомсдолд орох магадлалтай.

4. Логистик болон нийлүүлэлтийн сүлжээ:



- **Логистикийн шинэлэг шийдлүүд:** Цаг агаарын онц ноцтой үзэгдлүүдээс шалтгаалж логистикийн асуудлууд гарах болзошгүй тул бараа материалын эргэлтийг хэвийн үргэлжлүүлэхийн тулд логистикийн шинэлэг шийдлүүдийг ашиглах хэрэгцээ бий болно.
- **Даатгалтай холбоотой асуудлууд:** Логистик болон нийлүүлэлтийн сүлжээтэй холбоотой үйл ажиллагаануудыг даатгуулахад даатгалын үнэ өсөх зэрэг асуудлууд тулгарах.

5. Аюулгүй байдал:



- **Аюулгүй байдалд учирч болох эрсдэл:** Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллүүдээс үүдэн аюулгүй байдалтай холбоотой болзошгүй эрсдэлүүд нэмэгдэх магадлалтай байна.
- **Олон улсын нийлүүлэлтийн сүлжээн дэх аюулгүй байдал:** Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлүүдэд хариу арга хэмжээ авахын тулд бизнесүүд олон улсын нийлүүлэлтийн сүлжээн дэх аюулгүй байдлыг сайжруулах тал дээр анхаарлаа хандуулах шаардлага ирээдүйд бий болно.

6. Санхүү ба санхүүгийн менежмент:



- **Хөрөнгийн үнэ цэн алдагдах:** Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэж бизнесийн хөрөнгө оруулалтуудын үнэ цэн өөрчлөгдөж, технологийн хөгжил зэрэг шинэ нөхцөл байдал үүсэх магадлалтай.
- **Санхүүгийн нууцлалд тавигдах шаардлагууд:** Ирээдүйд бизнесүүдэд уур амьсгалтай холбоотой санхүүгийн эрсдэлүүд үүсгэж, ил тод байдлыг нэмэгдүүлэх шаардлага бий болгоно.

Дараах дасгал нь таны бизнесийн аль хэсэгт ямар аюул хэрхэн нөлөөлж болохыг тодорхойлох зорилготой юм. Таны бизнесийн үйл ажиллагаа, бүтэц, үйл явцад нөлөөлж болох ган, зуд, үер зэрэг болзошгүй аюулыг жагсааж, эдгээр аюулууд нь таны бизнесийн хэсэг бүрд хэрхэн нөлөөлж болохыг доорх хүснэгтэд тайлбарлан бичнэ үү.

Бизнесийн үйл ажиллагаа, бүтэц, эсвэл үйл явц	Ирээдүйд байгалийн аюулт үзэгдлүүд таны бизнес нөлөөлөх магадлалтай юу?	Таны бизнес ямар эрсдэлүүд нөлөөлөх вэ? (Хэт халалт, цар тахал зэрэг нэгээс олон эрсдэл байж болно)	Ирээдүйд таны бизнес сөрөг нөлөөллийг тайлбарлан бичнэ үү
Ажиллах хүчин	Тийм/ Үгүй		
Хэрэглэгчид, ханган нийлүүлэгчид болон гол оролцогч талууд	Тийм/ Үгүй		
Хөрөнгө, дэд бүтэц болон нөөц	Тийм/ Үгүй		
Логистик болон нийлүүлэлтийн сүлжээ	Тийм/ Үгүй		
Аюулгүй байдал ба хөдөлмөрийн эрүүл ахуй	Тийм/ Үгүй		
Санхүү, нягтлан бодох бүртгэл, ба санхүүгийн менежмент	Тийм/ Үгүй		
Бизнесийн үйл явц систем, дата болон мэдээллийн технологи	Тийм/ Үгүй		
Бусад (Аюулд өртөх магадлалтай бизнесийн бусад элементийг энд нэмнэ үү.)	Тийм/ Үгүй		


2.3 Уур амьсгалын эрсдэлийн түвшний үнэлгээ ба матриц

Өмнөх хэсэгт, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэйгээр бизнест учирч болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлсон. Харин энэ хэсэгт, дээр тодорхойлсон эрсдэлүүдийг эрсдэлийн тохиолдох магадлал, үр дагаврыг хэмжих замаар “эрсдэлийн зэрэг”-ийг тодорхойлоход чиглэнэ.

Ингэснээр, эрсдэлийн зэргээс хамааран авах хариу арга хэмжээний алхам, дарааллыг тодорхойлоход тусална. Дараах загварыг ашиглан эрсдэлийн зэргээ үнэлнэ үү.

Болзошгүй эрсдэлүүд	Магадлал (Магадлалтай маш багатай, Магадлал багатай, Боломжтой, Магадлалтай, Бараг тодорхой)	Үр дагавар (Ач холбогдолгүй, Бага, Дунд, Их, Аюултай)	Эрсдэлийн зэрэг (Бага, Дунд, Өндөр, Хэт их)

Тухайн эрсдэлийн тохиолдох магадлал, эрсдэлээс бий болох үр дагаварт үндэслэн эрсдэлийн зэргийг тогтооно. Жишээлбэл, эрсдэлийн тохиолдох магадлал “маш бага”, харин эрсдэлийн үр дагавар “аюултай” түвшинд бол эрсдэлийн зэрэг “дунд” хэмээн тодорхойлно.



III. Уур амьсгалын өөрчлөлтөд хариу арга хэмжээ авах төлөвлөгөөгөө гаргах нь

Энэ хэсэгт уур амьсгалын өөрчлөлтөд хариу арга хэмжээ авах төлөвлөгөөг гаргах зааварчилгааг оруулсан болно.

3.1. Хариу арга хэмжээний үйл ажиллагааг эрэмбэлэх нь

Бизнесийн үйл ажиллагаанд богино, дунд, урт хугацаандаа хэрэгжүүлэх хариу арга хэмжээг төлөвлөхдөө дараах асуултуудыг харгалзаж, ач холбогдлын түвшнээр нь эрэмбэлэх чухал байдаг. Үүнд:

- **Үр дүнтэй байдал:** Эдгээр үйл ажиллагаанууд танай байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилтуудтай нийцэж байна уу?
- **Үр ашигтай байдал:** Үйл ажиллагааны үр ашиг нь зардлаа давж чадаж байна уу?
- **Тэгш байдал:** Үйл ажиллагаа нь бусад орон нутаг болон нийгмийн эмзэг бүлэгт сөргөөр нөлөөлөх үү?
- **Уян хатан байдал:** Үйл ажиллагааг уян хатан, үе шаттайгаар хэрэгжүүлж, шаардлагатай өөрчлөлтийг оруулах боломжтой байна уу?
- **Тогтвортой байдал:** Үйл ажиллагаа нь тогтвортой байдлын зорилтуудад хувь нэмрээ оруулах уу? Тогтвортой хөгжлийг дэмжсэн байж чадах уу?
- **Хэрэгжихүйц байдал:** Үйл ажиллагааны хариу арга хэмжээ нь тодорхой цаг хугацаанд хэрэгжиж болохуйц байна уу?
- **Хууль ёсны байдал:** Үйл ажиллагаа нь улс төр болон нийгмийн хувьд хүлээн зөвшөөрөгдөхүйц байна уу?
- **Хойшлуулшгүй байдал:** Үйл ажиллагааг хэр яаралтай хэрэгжүүлэх боломжтой байна вэ?
- **Өртөг:** Үйл ажиллагааны хувьд эдийн засгийн зардлаас гадна, нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, зардлыг тооцсон уу?
- **Тогтвортой байдал:** Үйл ажиллагаа нь ирээдүйд тохиох уур амьсгалын өөрчлөлтөд ач холбогдол, хамааралтай хэвээр байж чадах уу?



3.2 Богино хугацааны хариу арга хэмжээ авах төлөвлөгөө (1 жил хүртэлх)

Энэ хэсэгт, жижиг, дунд бизнес эрхлэгчид Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй тулгамдсан асуудлуудыг богино хугацаанд буюу (1 жилээс бага) түргэн шуурхай шийдвэрлэх боломжтой хариу арга хэмжээнүүдийг авч үзнэ.

Бизнесүүд өөрийн үйл ажиллагааны хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлийг даван туулах, бууруулахын тулд богино хугацаанд хэрэгжүүлж болох олон төрлийн арга хэмжээнүүд байдаг. Тухайлбал, жижиг, дунд бизнесүүд байгалийн гамшигт үзэгдлүүд, нийлүүлэлтийн сүлжээний тасалдал зэрэг бизнест тулгарах шууд эрсдэлийг тодорхойлж, тэдгээрийг бууруулах арга хэмжээг богино хугацаандаа чухалчлах хэрэгтэй. Авч хэрэгжүүлж болох зарим арга хэмжээнүүдийг дурдвал,

- **Яаралтай хариу арга хэмжээ авах сургалт:** Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сорилт, бэрхшээл болон байгалийн гамшигт үзэгдлийн үед яаралтай авах хариу арга хэмжээний талаар ажилтнуудыг сургалтад хамруулах.
- **Эрсдэлийн анхан шатны үнэлгээ:** Бизнесийн үйл ажиллагаа болон дэд бүтцэд учрах боломжтой уур амьсгалын өөрчлөлт болон байгалийн гамшигт үзэгдэлтэй холбоотой шууд эрсдэлийг тодорхойлох түргэвчилсэн үнэлгээ хийх.
- **Дэд бүтцийг шинэчлэх богино хугацааны арга хэмжээнүүд:** Шууд нөлөөлөхүйц аюул, эрсдэлд тэсвэрлэх чадвараа нэмэгдүүлэхийн тулд дэд бүтцээ сайжруулах шуурхай, хямд төсөр арга хэмжээнүүд авч хэрэгжүүлэх.
- **Харилцаа холбооны зааварчилгаа:** Уур амьсгалын өөрчлөлт болон байгалийн гамшигт үзэгдлээс үүдэлтэй онцгой байдлын үед харилцаа холбоогоо зохицуулах зааварчилгаа боловсруулах.
- **Нийлүүлэлтийн сүлжээний тэсвэртэй байдлын үнэлгээ:** Богино хугацааны эмзэг байдал, болзошгүй үйл ажиллагааны доголдлыг илрүүлэхийн тулд нийлүүлэлтийн сүлжээнд урьдчилсан үнэлгээ хийх.

Өөрсдийн тодорхойлсон эрсдэл тус бүр дээр бизнест тань тохирох богино хугацааны хариу арга хэмжээнүүдийг жагсаагаарай. Танай бизнесийн үнэт зүйлс, эрхэм зорилго, үндсэн үйл ажиллагааны чиглэл, чадавхад тохирох эсэхийг бодолцоорой.

Эрсдэл (Өмнөх хүснэгтээс авах)	Эрсдэлийн эсрэг хэрэгжүүлэх богино хугацааны хариу арга хэмжээнүүд

3.3 Дунд хугацааны хариу арга хэмжээ авах төлөвлөгөө (1-3 жил)

Энэ хэсэгт жижиг, дунд бизнес үүд уур амьсгалд тэсвэртэй байдлаа нэмэгдүүлэхэд илүү гүнзгийрч ажиллах хугацаа буюу дунд хугацааны (1-3 жилийн) үйл ажиллагааг төлөвлөнө. Тухайлбал, (i) үйл ажиллагаандаа уур амьсгалд өөрчлөлтөд нийцсэн ухаалаг технологийг нэвтрүүлэх, (ii) уур амьсгалаас хамааралтай эмзэг байдлаа бууруулахын тулд нийлүүлэлтийн сүлжээгээ төрөлжүүлэх, (iii) уур амьсгалын өөрчлөлтөө нөлөөллийг тооцоолон бүтээгдэхүүн, үйлчилгээний инновац, шинэчлэлийг нэмэгдүүлэх зэрэг тогтвортой хүчин чармайлтыг хамруулна.

Бизнесийн үйл ажиллагаандаа тойрог эдийн засгийн зарчмууд, тогтвортой бизнесийн практикуудыг нэвтрүүлэх нь дунд хугацааны тэсвэртэй байдлын салшгүй хэсэг юм. Тухайлбал:

- **Тэсвэртэй дэд бүтцийн төлөвлөлт:** Дунд хугацаандаа тэсвэртэй байдлаа нэмэгдүүлэхийн тулд дэд бүтцээ шинэчлэх цогц төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх.
- **Нийлүүлэлтийн сүлжээ төрөлжүүлэлт:** Нийлүүлэлтийн сүлжээний нэг талаас хамаарсан байдлаа бууруулж, ханган нийлүүлэгчдээ төрөлжүүлж, ханган нөөц төлөвлөгөө гаргах.
- **Ажилчдад зориулсан тогтвортой практикийн сургалт:** Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, бууруулах арга хэмжээнүүдийн талаар гүнзгий мэдээлэлтэй болох сургалтын хөтөлбөр гаргах, хэрэгжүүлэх.
- **Ногоон худалдан авалтын бодлого:** Бизнесийн түвшинд байгаль орчинд ээлтэй, нүүрсхүчлийн хий бага ялгаруулах бүтээгдэхүүн, үйлчилгээнд анхаарсан дунд хугацааны худалдан авалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх.
- **Ногоон технологийн хэрэглээ:** Эрчим хүчний үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх, байгаль орчны нөлөөллийг бууруулахад дунд хугацаандаа ашиглаж болох технологиудад хөрөнгө оруулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх.
- **Ахисан түвшний эрсдэлийн үнэлгээ:** Дунд хугацаанд орон нутгийн уур амьсгалд гарах өөрчлөлтийг харгалзан нарийвчилсан эрсдэлийн үнэлгээ хийх.

Өөрсдийн тодорхойлсон эрсдэл тус бүрдээ бизнест тань тохирох дунд хугацааны хариу арга хэмжээнүүдийг жагсаагаарай. Танай бизнесийн зорилго, чадавхад тохирох эсэхийг бодолцоорой.

Эрсдэл (Өмнөх хүснэгтээс авах)	Эрсдэлийн эсрэг хэрэгжүүлэх дунд хугацааны хариу арга хэмжээнүүд

3.4 Урт хугацааны хариу арга хэмжээ авах төлөвлөгөө (3 жилээс дээш)

Урт хугацааны хариу арга хэмжээний төлөвлөгөө нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг даван туулах чадавхыг бий болгохын тулд тухайн бизнес урт хугацааны туршид авах арга хэмжээ, үйл ажиллагаануудыг тодорхойлсон стратегийн зураглал юм.

Энэхүү төлөвлөгөө нь ихэвчлэн олон жилийг хамрах ба уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжуудыг тодорхойлох, үнэлэх, шийдвэрлэх цогц аргачлалыг тусгана. Үүнд:

- **Уур амьсгалд тэсвэртэй дэд бүтцийн хөгжил:** Урт хугацаанд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг тэсвэрлэх барилга байгууламж, дэд бүтцийг хөгжүүлэх, хөрөнгө оруулах.
- **Усны менежментийн стратеги:** Урт хугацаандаа тогтвортой усны хэрэглээг хангах, хур тунадасны өөрчлөлтөд хариу үзүүлэх усны менежментийн цогц стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх.
- **Тойрог эдийн засгийн хэрэглээ:** Хог хаягдлыг бууруулж, дахин хэрэглээ, дахин боловсруулалтыг нэмэгдүүлэх тойрог эдийн засгийн загвар руу шилжих.
- **Даатгалын шинэлэг шийдлүүд:** Уур амьсгалтай холбоотой эрсдэлд нийцсэн, урт хугацааны даатгалын шинэлэг шийдлүүдийг боловсруулж хэрэгжүүлэх тал дээр даатгалын байгууллагуудтай хамтран ажиллах.
- **Судалгаа ба хөгжил:** Уур амьсгалд урт хугацаанд тэсвэртэй технологийг ашиглахын тулд судалгаанд хөрөнгө оруулалт хийх.
- **Дасан зохицохуйц бизнесийн загвар боловсруулах:** Уур амьсгалын өөрчлөлт, зах зээлийн динамик байдалд урт хугацаанд уян хатан хариу үйлдэл үзүүлэх чадвартай дасан зохицох бизнесийн загваруудыг судалж, хэрэгжүүлэх.
- **Хүний нөөцийн тэсвэртэй бодлого:** Ажлын уян хатан зохицуулалт, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжлэг зэрэг уур амьсгалтай холбоотой урт хугацааны өөрчлөлтүүдийн үед ажилчдыг дэмжих хүний нөөцийн бодлогыг боловсруулах.

Өөрсдийн тодорхойлсон эрсдэл тус бүрдээ бизнест тань тохирох урт хугацааны хариу арга хэмжээнүүдийг жагсаагаарай. Танай бизнесийн зорилго, чадавхад тохирох эсэхийг бодолцоорой.

Эрсдэл (Өмнөх хүснэгтээс авах)	Эрсдэлийн эсрэг хэрэгжүүлэх урт хугацааны хариу арга хэмжээнүүд

IV. Хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжүүлэлт

Өмнөх хэсгүүдэд үндэслэн тодорхойлсон богино, дунд, урт хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцах үүрэг бүхий хүмүүсийг тодорхойлно уу. Мөн үйл ажиллагаа тус бүрийн зардлыг тооцоолно уу. Энэ нь хариу арга хэмжээ авах төлөвлөгөө нь танай бизнестэй хэрхэн уялдаж байгааг харж, цаашдын хэрэгжилтийг хангахад тань тусална.

Үйл ажиллагаа	Хариуцах эггээд	Хэрэгжүүлэхэд шаардагдах зардал (ойролцоогоор, төгрөгөөр)
Богино хугацааны хариу арга хэмжээ авах төлөвлөгөө (1 жил хүртэлх)		
Дунд хугацааны хариу арга хэмжээ авах төлөвлөгөө (1-3 жил)		
Урт хугацааны хариу арга хэмжээ авах төлөвлөгөө (3 жилээс дээш)		

V. Хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх болон хянах процесс

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээ нь таны бизнесийн эрсдэлийн удирдлага болон ирээдүйн бизнесийн төлөвлөгөөтэй хэрхэн уялдаж байна вэ? Боловсруулсан хариу арга хэмжээний төлөвлөгөөгөө үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд дараах зөвлөмжийг дагаарай.

- **Бизнесийн үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөөтэй уялдуулах:** Уур амьсгалын өөрчлөлтийн хариу арга хэмжээний төлөвлөгөөгөө бизнесийн алсын хараа, эрхэм зорилго, бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулах.
- **Бизнесийн үйл ажиллагааны эрсдэлийн менежментийн төлөвлөгөөтэй уялдуулах:** Хэрэглэгдэхүүний дагуу тодорхойлсон эрсдэлүүдийг одоо бизнесийн үйл ажиллагаандаа ашиглаж буй эрсдэлийн менежментийн төлөвлөгөөтэй нэгтгэснээр бизнесийн орчин дэх эрсдэлүүдийг цогцоор богино, дунд, урт хугацаанд харах боломжийг олгоно.
- **Чадавхыг тогтмол сайжруулах, бэхжүүлэх:** Бизнесийн үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, гүйцэтгэлийн түвшинд ажиллаж байгаа ажилчдын уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшигт үзэгдлийг даван туулах, хариу арга хэмжээний талаарх ойлголт, мэдлэгийг тогтмол нэмэгдүүлэх.
- **Хяналт, шинжилгээ, мониторингийн тогтолцоог бий болгох:** Бизнесийн үйл ажиллагаанд үзүүлэх уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, сорилтуудыг бүртгэж, холбогдох төлөвлөлтийн хяналт, үнэлгээг хийснээр өөрчлөлтийг удирдах боломжийг бүрдүүлнэ. Хяналт, шинжилгээнд оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлснээр талуудын мэдлэгийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ. Мөн хариу арга хэмжээний төлөвлөлтөд нөлөөлөх санхүү, хүний нөөц зэрэг асуудлуудыг бүрэн хамруулах, орхигдуулахгүй байхад тусална. Тиймээс уур амьсгалын өөрчлөлтийн хариу арга хэмжээний төлөвлөгөөгөө үр дүнтэй байлгахын тулд тогтмол хяналт шинжилгээ хийхийг зөвлөж байна.

Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг ирээдүйн бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагаандаа үр дүнтэйгээр нэгтгэхийн тулд байгууллага дотроо уур амьсгалын өөрчлөлтөд мэдрэмжтэй соёлыг төлөвшүүлэх зайлшгүй шаардлагатай. Уур амьсгалын эрсдэлийг ойлгож, хариу арга хэмжээ авах чадвар бүхий багийг бүрдүүлэхийн тулд ажилчдыг сургах, мэдээлэл түгээх үйл явц, санаачилгад хөрөнгө оруулах шаардлагатай. Түүнчлэн ногоон бизнесийн боломжуудыг судалж, сонирхогч талуудтай хамтран ажиллах замаар уур амьсгалд тэсвэртэй байдлыг бий болгоход хувь нэмрээ оруулж болох юм.



Хавсралт: Хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулахдаа ашиглах боломжтой чухал асуултууд

Уур амьсгалын өөрчлөлтийн хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулахдаа дараах асуултуудыг бодолцоорой.

- 1 Ажилтнууд, хэрэглэгчид, захиалагчид, ханган нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч талууд болон бусад холбогдох талуудтай холбоо барих мэдээллийн шинэчлэгдсэн жагсаалт байдаг уу? Энэ нь байгалийн гамшигт үзэгдлийн үед үйл ажиллагаагаа удирдах, төлөвлөх, зохион байгуулахад туслах болно.
- 2 Байгалийн гамшигт, аюулт үзэгдлийн үед ажиллах ажлын уян хатан цагийн зохицуулалт байдаг уу? Мөн, энэ үед бизнесийн тасралтгүй байдлыг алдагдуулахгүйгээр хэрхэн ажиллахаа төлөвлөсөн үү?
- 3 Танд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сорилтууд, байгалийн гамшигт үзэгдлээс ажлын байраа хамгаалахад зориулагдсан багаж, хэрэгсэл (жишээ нь, элстэй шуудай, эсвэл үерийн хаалт г.м) байгаа юу?
- 4 Танай бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа барилга, байгууламж өндөр температур (халуун, хүйтэн)-ыг хэр тэсвэрлэх чадвартай вэ?
- 5 Байгалийн гамшигт, аюулт үзэгдлийн дараа ажлын байр, техник хэрэгслээ цэвэрлэх хэрэгсэл, багаж, ур чадвар байгаа юу? Цэвэрлэгээний хэрэгслээ одоогийн байдлаар худалдаж авах санхүү, хүний нөөц болон бусад чадавх, боломж байгаа юу?
- 6 Байгалийн гамшигт, аюулт үзэгдэлд нэрвэгдсэн тохиолдолд түр өөр газар руу нүүх боломжийг судалж үзсэн үү?
- 7 Бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа ажлын байраа илүү эрсдэл багатай, аюулгүй байршилд шилжүүлэх талаар бодож үзсэн үү?
- 8 Хэрэв бизнесийн үйл ажиллагаа явуулж буй байраа түрээсэлдэг бол, түрээслэгчтэйгээ уур амьсгалтай холбоотой эрсдэлийн талаар ярилцсан уу?
- 9 Танай бизнесийн бүтээгдэхүүн, үйлчилгээ байгаль, цаг агаар уурын онцлог болон уур амьсгалын хүчин зүйлсийг харгалзсан үздэг үү?
- 10 Та нийлүүлэлтийн сүлжээгээ төрөлжүүлэх талаар бодож үзсэн үү? (Өөрөөр хэлбэл, өөр өөр газарзүйн бүс нутгаас түүхий эд болон бусад холбогдох үйлчилгээг авдаг уу)?
- 11 Танай ханган нийлүүлэгчид (өөр байршилд) болон зах зээлүүдийн дунд уур амьсгалын өөрчлөлтөд өртөж болзошгүй байршилд байгаа талууд байгаа юу?
- 12 Танай бизнес өгөгдөл, мэдээлэл баримтаа хадгалахын зэрэгцээ, чухал мэдээллээ аюулгүй газар давхар хадгалж чадсан уу? (жишээ нь зөөврийн компьютер, компьютер, сервер гэх мэт)
- 13 Танай бизнесийн санхүүд байгаль, цаг уурын гамшигт, аюулт үзэгдэл хэрхэн нөлөөлдөг вэ?
- 14 Танай бизнесийн үйл ажиллагааг даатгалд хамруулахад хэр төвөгтэй байдаг вэ? Даатгалд хамрагдахад нөлөө үзүүлж буй хүчин зүйлсийг харгалзан бизнесийн одоогийн болон ирээдүйн хэрэгцээ, сонирхолдоо нийцүүлэн тохиромжтой даатгалаа сонгосон гэдэгтээ итгэлтэй байна уу?
- 15 Та бизнесээ байгалийн гамшигт, аюулт эрсдэлүүд болох үер, салхи шуурга зэргээс хамгаалах даатгалд даатгуулсан уу? Танай бизнесийн үйл ажиллагаанд бий болох даатгалд хамрагдаагүй эрсдэл байгаа юу?
- 16 Танай байгууллагын хамрагдсан даатгалд хуучин эд зүйлс (тоног төхөөрөмж, нийлүүлэлт, бүтээгдэхүүн, г.м.)-ийг шинээр солих эсвэл засвар хийх зохицуулалт бий юу?
- 17 Танай байгууллагын хамрагдсан даатгалд үер зэрэг байгалийн гамшигт, аюулт үзэгдлээс үүдэн гарсан нэмэлт зардлыг богино хугацаанд санхүүжүүлэх механизмыг тусгаж өгсөн үү?

Эх сурвалж: Фахим Тонмой, Дэвид Риссик, Жижиг бизнесүүдэд зориулсан уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн менежментийн хэрэглэгдэхүүн

IRIM судалгааны хүрээлэн



301 тоот, 48-р барилга, Бага тойруу, 6-р хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар, Монгол



46A/265 Улаанбаатар, Монгол



www.irim.mn



IRIMongolia



[irim_mongolia](https://twitter.com/irim_mongolia)



[irim_mongolia](https://www.instagram.com/irim_mongolia)



+976-7011-7101



contact@irim.mn